




ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ИНГЭЖ 2022
ШИНЭЧИЛЬЕ
ШИНЭ САНААНЫ УРАЛДААН

ХХААХҮ салбарын хөгжлийг дэмжих

ИНГЭЖ  **2022**
ШИНЭЧИЛЬЕ
ШИНЭ САНААНЫ УРАЛДААН



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ИНГЭЖ 2022
ШИНЭЧИЛЬЕ
ШИНЭ САНААНЫ ТРАФЕК

БАТЛАВ.
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ДЭД САЙД



М.ГАНХҮЛЭГ

ХХААХҮ-ийн салбарын хөгжлийг дэмжих
“ИНГЭЖ ШИНЭЧИЛЬЕ - 2022”
шинэ санааны уралдааны удирдамж

Улаанбаатар хот

2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

НЭГ. ЗОРИЛГО

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн салбарын төрийн албан хаагчдын бүтээлч сэтгэлгээ, оновчтой шийдэл, шинэ санаачилгыг дэмжиж, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн үр ашиг өндөр үйлдвэрлэл, үйлчилгээний инновацыг төрийн бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.

ХОЁР. ШИНЭ САНАА АВАХ ХУГАЦАА

2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам, түүний харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагын нийт төрийн албан хаагчид.

ДӨРӨВ. ШИНЭ САНАА ХҮЛЭЭН АВАХ

Оролцогч дэвшүүлж буй шинэ санаагаа <https://forms.gle/HaY4CxMwWoFEZxAU6> цахим форм ашиглан илгээнэ. Нэг оролцогч олон удаа шинэ санаа гаргаж болох ба дараах чиглэлийн хүрээнд байна.

Үүнд:

- Монгол Улсын Засгийн Газрын санаачилга Алсын Хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжсэн;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилтуудтай нийцсэн;
- Салбарын төрийн бодлого, үйл ажиллагаанд тулгамдаж буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхүйц, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилго, зорилттой уялдсан;
- Уламжлалт арга барил, хандлагыг өөрчлөх, цахим шилжилтийг дэмжсэн;
- Үйл ажиллагааны зардлыг бууруулсан, төсөв хэмнэсэн;
- Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдалд эергээр нөлөөлсөн;
- Хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, ажлын процессыг боловсронгуй болгосон;



- Олон улсад амжилттай туршигдсан загварыг нутагшуулсан;
- Салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх, уялдааг сайжруулах.

ТАВ. УРАЛДААНЫГ ҮНЭЛЭХ, УРАМШУУЛАХ

ХХААХҮ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 12 дугаар сард багтаан уралдааныг дүгнэнэ.

- Уралдаанд хамгийн идэвхтэй оролцсон газар, хэлтэс, харьяа байгууллагыг шалгаруулна;
- Хамгийн шилдэг шинэ санааг дэвшүүлсэн 10 хүртэлх оролцогчийг “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар урамшуулж, олон нийтэд зарлана. Мөн шинэ санаагаа бодитой хэрэгжүүлэх зорилгоор олон улсын туршлага судлах сургалт, хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх, цаашид салбартаа өсөн дэвжих боломжийг олгоно.

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам
- Хөдөө Аж Ахуйн Бирж ТӨХХК
- Монголын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Байгаль Орчны ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо
- Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл

Дэлгэрэнгүй мэдээллийг ХХААХҮ-ийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, 51-262907 утаснаас тодруулна уу.